

БАНКНЫ ЗЭЭЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэ журмын зорилго нь банкны зээлийн эрсдэлийн дуршил (credit risk appetite), зээлийн бодлогыг тодорхойлох, банкнаас төлбөр хариуцагчид зээл олгоход баримтлах зарчим, тавих шаардлагыг тогтоох, зээлийн судалгааг хийх, зээл олгох шийдвэр гаргах, зээлийн хувийн хэргийг бүрдүүлэх, олгосон зээлд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Банк нь өөрийн хөрөнгө, эрсдэлийн удирдлага, хууль журмын хүрээнд хүлээж чадах хамгийн их эрсдэлийн түвшин (risk capacity) (цаашид “эрсдэлийн чадамж” гэх), өөрийн бизнесийн стратеги, бизнес төлөвлөгөөний хүрээнд зээлийн үйл ажиллагаанаас хүлээх зээлийн эрсдэлийн түвшин (цаашид “зээлийн эрсдэлийн дуршил” гэх)-г тодорхойлсон байна.
- 1.3 Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, зээлийн эрсдэлийн дуршлын хүрээнд зээлийн үйл ажиллагаа эрхлэхэд баримтлах зарчим, шийдвэр гаргалт, хяналтын тогтолцоог тодорхойлсон бодлого (цаашид “зээлийн бодлого” гэх)-той байна.
- 1.4 Банк нь зээл олгох, олгосон зээлийг хянах үйл ажиллагааны бүх шатанд зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогыг баримталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- 1.5 Банкны зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогыг банкны Төлөөлөн удирдах зөвлөл баталж, Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, хэрэгжилтэд энэ журмын 1.15-д тодорхойлсон Эрсдэлийн удирдлага хариуцсан удирдах ажилтан хяналт тавьж ажиллана.
- 1.6 Банк зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогыг тодорхой давтамжийн дагуу, жилд нэгээс доошгүй удаа хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн батална.
- 1.7 Эдийн засгийн болон бизнесийн орчны нөхцөл байдалтай уялдуулан банк зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогыг жилд 1-ээс олон удаа шинэчлэн баталж болно.
- 1.8 Банк зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогын хүрээнд зээлийн хүсэлтийг судлах, зээлийн эрсдэлийг үнэлэх, зээлдэгчийн зээлжих зэрэглэл (credit rating)-ийг тогтоох, зээл олгох шийдвэр гаргах, олгосон зээлийг хянах журам, заавар, арга, аргачлалыг энэ журамд нийцүүлэн дотооддоо боловсруулж, мөрдөж ажиллана.

ТӨСӨЛ

- 1.9 Энэ журмын 1.8-д заасан журам, заавар, арга аргачлалыг банкны Гүйцэтгэх захирал баталж, хэрэгжүүлж ажиллана.
- 1.10 Банкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж нь зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлого, энэ журмын 1.8-д заасан журам, заавар, арга, аргачлалыг тодорхой давтамжийн дагуу хянаж, шинэчилнэ.
- 1.11 Банк зээл олгохтой холбоотой үйл явц, үе шат, хариуцах ажилтан, түүний үүрэг, хариуцлагыг холбогдох дотоод журам, зааварт нарийвчлан заана.
- 1.12 Банкны зээлийн үйл ажиллагааны үйл явц, үе шатанд оролцох ажилтнууд нь банкны зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогын талаар мэдлэгтэй, мэргэжлийн ур чадвартай байх бөгөөд банк эдгээр ажилтнуудыг тогтмол мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулдаг байна.
- 1.13 Банк нь зээлийн үйл ажиллагааг зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлого болон тэдгээрийн хүрээнд баталсан журам зааврын дагуу эрхэлж байгаа эсэхэд хяналт тавьж, зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогын зохистой, үр ашигтай байдалд үнэлэлт дүгнэлт өгч, хянах шат дараалсан хяналтын тогтолцоо, удирдлага, засаглалын бүтэцтэй байна.
- 1.14 Энэ журмын 1.13-ын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ Эрсдэлийн удирдлагын хороо болон Аудитын хороотой байх бөгөөд Аудитын хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнийг томилно. Эрсдэлийн удирдлагын хорооны нэг гишүүн нь Аудитын хорооны гишүүн байна.
- 1.15 Энэ журмын 1.13-ын хүрээнд Банк нь эрсдэлийн удирдлага хариуцсан нэгжийг удирддаг, Гүйцэтгэх захирлаас хараат бус албан тушаалтан (цаашид “Эрсдэлийн удирдлага хариуцсан удирдах ажилтан”)-тай байх бөгөөд Эрсдэлийн удирдлага хариуцсан удирдах ажилтан нь Эрсдэлийн хороонд шууд тайлагнах, Гүйцэтгэх захиралд мэдээлэх эрх, үүрэгтэй байна.

ХОЁР. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ДУРШИЛ

- 2.1 Банкны зээлийн эрсдэлийн дуршлын баримт бичгийг Эрсдэлийн удирдлагын хорооны удирдлаган дор банкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж боловсруулж, энэ журмын 1.5-ын дагуу ТУЗ батална.
- 2.2 Банк зээлийн эрсдэлийн дуршлыг тодорхойлохдоо дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:
 - 2.2.1 Өөрийн хөрөнгө;
 - 2.2.2 Бизнесийн стратеги;
 - 2.2.3 Бизнес төлөвлөгөө;
 - 2.2.4 Эрсдэлийн удирдлага;

ТӨСӨЛ

- 2.2.5 Эрсдэлийн чадамж (risk capacity);
- 2.2.6 Банкны үйл ажиллагаанд хууль, журмаар тогтоосон хязгаарлалтууд.
- 2.3 Банкны зээлийн эрсдэлийн дуршлыг тодорхойлсон баримт бичиг дор дурдсан бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:
 - 2.3.1 Нийт зээлийн багцын бүтэц;
 - 2.3.2 Зээлийн бүтээгдэхүүн бүрийн хувьд нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээний дээд хязгаар (зээлжих зэрэглэлээс шалтгаалан нэг зээлдэгчид олгох зээлийн хязгаар ялгаатай байж болно);
 - 2.3.3 Зээлийн багцын төвлөрлийн хязгаар буюу тухайн зээлийн бүтээгдэхүүн эсхүл эдийн засгийн салбарт олгох зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувийн дээд хязгаар;
 - 2.3.4 Хамтын санхүүжилттэй зээлийн гэрээнд оролцох дээд хязгаар;
 - 2.3.5 Гадаад валютаар олгох зээлийн нийт төгрөгөөр олгох зээлийн үлдэгдэлд харьцуулсан хувийн дээд хязгаар (валют тус бүрээр);
 - 2.3.6 Холбогдох этгээдэд олгох зээлийн дээд хязгаар;
 - 2.3.7 Нэг этгээд, түүний холбогдох этгээдэд олгох зээлийн дээд хязгаар;
 - 2.3.8 Харилцан хамаарал бүхий этгээдэд олгох зээлийн дээд хязгаар;
 - 2.3.9 Зээл олгох зорилтот харилцагчдын тодорхойлолт;
 - 2.3.10 Зээл олгох зорилтот эдийн засгийн салбар;
 - 2.3.11 Зээл олгохоос зайлсхийх харилцагчдын тодорхойлолт;
 - 2.3.12 Зээл олгохоос зайлсхийх эдийн засгийн салбар, бизнесийн үйл ажиллагаа;
 - 2.3.13 Бусад шаардлагатай хязгаарлалтууд.
- 2.4 Банкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж нь зээлийн эрсдэлийн дуршлын хүрээнд тогтоох зээлийн хязгаарлалтуудыг эдийн засгийн мөчлөг, хүүгийн болон зах зээлийн бусад өөрчлөлт, хөдөлгөөнийг харгалзан мэдрэмтгий байдлын шинжилгээ (stress test)-ний үр дүнд тулгуурлаж, тооцоолсны үндсэн дээр тогтооно.
- 2.5 Банк нь зээлийн багцыг зээлийн эрсдэлийн дуршлын хүрээнд зохистой хэмжээнд удирдана.

ГУРАВ. БАНКНЫ ЗЭЭЛИЙН БОДЛОГО

- 3.1 Банкны зээлийн бодлогыг Эрсдэлийн удирдлагын хорооны дэргэдэх банкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж боловсруулж, энэ журмын 1.5-ын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл батална.
- 3.2 Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж нь зээлийн бодлогыг боловсруулахдаа банкны зохистой үйл ажиллагаа болон Монголбанкнаас тогтоосон шаардлагын хүрээнд өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, хүний нөөцийн болон технологийн нөөц бололцоог харгалзан үзнэ.
- 3.3 Банк нь зээлийн бодлогод энэ журамд нийцүүлэн зээлийн үйл ажиллагаа эрхлэхэд баримтлах зарчим, шийдвэр гаргалт, хяналтын тогтолцоог тодорхойлохоос гадна дараах бүрэлдэхүүн хэсгийг тусгана. Үүнд:
 - 3.3.1 Зээлийн бүтээгдэхүүн тус бүрийн хувьд зээл олгох шалгуур, шаардлага;
 - 3.3.2 Гадаад валютаар олгох зээлийн бодлого;
 - 3.3.3 Зээлийн эрсдэлийг тогтоох, үнэлэх, хянах, удирдах бодлого, зарчим;
 - 3.3.4 Хамтын санхүүжилттай зээлийн гэрээнд оролцоход баримтлах бодлого, зарчим;
 - 3.3.5 Байгаль орчин, нийгмийн талаар баримтлах бодлого, зарчим;
 - 3.3.6 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд баримтлах бодлого;
 - 3.3.7 Зээлийн хүсэлтийг хүлээж авахаас зээл олгох шийдвэр гаргах хүртэлх үйл явц, үе шат, хариуцах үйл ажиллагааны нэгж, албан тушаалтан, тэдгээрийн эрх үүрэг;
 - 3.3.8 Зээл олгох шийдвэр гаргах эрх бүхий зээлийн хороо(д), албан тушаалтан, тэдгээрийн эрх хэмжээ, шийдвэрлэх зээлийн дүнгийн дээд хязгаар;
 - 3.3.9 Зээлийн хороо(д), албан тушаалтны шийдвэрлэх зээлийн бүтээгдэхүүний төрөл;
 - 3.3.10 Зээлийн бодлого, зээлийн эрсдэлийн дуршилд заасан хязгаарлалтаас хэтэрсэн, харьяалагдахгүй зээлийг хэрхэн шийдвэрлэх бодлого болон эдгээр зээлийг шийдвэрлэх үе шат, шийдвэрлэх дээд шатны хороо, эрх бүхий этгээд, тэдгээрийн эрх хэмжээ;
 - 3.3.11 Зээлийн бодлого, зээлийн эрсдэлийн дуршилд заасан хязгаарлалтаас хэтэрсэн, харьяалагдахгүй зээлийн хүсэлтийг дараагийн шатны эрх бүхий этгээдэд мэдэгдэх, шийдвэрлүүлэхээр шилжүүлэх нөхцөл, үе шат;

ТӨСӨЛ

- 3.3.12 Зээл олгосны дараах хяналтыг хийх бодлого зарчим, үе шат, хариуцах үйл ажиллагааны нэгж, албан тушаалтан, тэдгээрийн эрх үүрэг;
 - 3.3.13 Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх бодлого;
 - 3.3.14 Зээлийн бүтээгдэхүүний хугацаа, хүүг тогтоох зарчим;
 - 3.3.15 Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоох, зээлийн эргэн төлөлтийн чадамжийг үнэлэх зарчим;
 - 3.3.16 Монголбанкнаас баталсан “Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам”-ын хүрээнд өөрийн холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээд, банкны ажилтан болон банкны ажилтны хамааралтай этгээдэд олгох зээлийн бодлого;
 - 3.3.17 Барьцаа хөрөнгийн талаар баримтлах бодлого, зарчим;
 - 3.3.18 Зээлийн гэрээнд бүтцийн өөрчлөлт хийх бодлого, зарчим;
 - 3.3.19 Зээлийн бүтээгдэхүүний төрлөөс шалтгаалан гэрээнд тусгах нэмэлт нөхцөлүүд, зээлийн шугам болон зээлийг хэсэгчлэн олгох тохиолдолд зээлийн санхүүжилтийг үргэлжлүүлэн олгох нөхцөлүүд (covenants);
 - 3.3.20 Шаардлагатай гэж үзсэн бусад бодлого, зарчим.
- 3.4 Банк нь энэ журмын 3.3.10, 3.3.11-ийн хүрээнд зээлийн бодлого, зээлийн эрсдэлийн дуршилд заасан хязгаарлалтаас хэтэрсэн, харьяалагдахгүй зээлийг шийдвэрлэх үйл явц, үе шат, хяналт, тайлагналыг зохицуулсан дотоод журамтай байна.
 - 3.5 Банк нь энэ журмын 3.3.13-т заасан шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх бодлогод нийцүүлэн боловсруулсан журамтай байх бөгөөд тус журамд зээлийн бүтээгдэхүүн бүрийн хувьд зээл олгоход тавигдах шаардлага, зээлийн хүү, хугацаа, зорилгот зээлдэгчийн бүлгийг батлах этгээд (цаашид “Шинэ бүтээгдэхүүний хороо” гэх), түүний эрх хэмжээг тодорхойлно.
 - 3.6 Шинэ бүтээгдэхүүний хороо нь Гүйцэтгэх захирлын дэргэдэх хороо байх бөгөөд банк нь тус хорооны бүтэц, бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлага, хорооны ажиллах горимыг тодорхойлсон дотоод журамтай байх бөгөөд энэхүү журмыг жилд 1 удаа хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн батална.
 - 3.7 Энэ журмын 3.3.14-т заасан зээлийн бүтээгдэхүүний хүү тогтоох зарчмыг банкны зээлийн эрсдэлийн дуршил, бизнесийн стратеги, бизнес төлөвлөгөө, ашигт ажиллагаа, зээлийн бүтээгдэхүүний онцлог, зорилгот зээлдэгчдийн эрсдэлийн түвшинд тулгуурлан дараах зардлуудыг харгалзан тогтооно. Үүнд:
 - 3.7.1 Өөрийн хөрөнгийн зардал (Cost of capital);
 - 3.7.2 Эх үүсвэрийн зардал;

- 3.7.3 Үйл ажиллагааны болон захиргааны зардал;
 - 3.7.4 Зээлийн эрсдэлийн зардал (хүлээгдэж буй алдагдлын загвараар тооцоолсон эсхүл өмнөх хугацааны зээлийн эрсдэлд тулгуурлан тооцоолсон байх);
 - 3.7.5 Татварын болон бусад хамаарах зардлууд.
- 3.8 Банк нь энэ журмын 3.3.16-д заасан өөрийн холбогдох этгээд, хамаарал бүхий этгээд, банкны ажилтан болон банкны ажилтны хамааралтай этгээдэд олгох зээлийн бодлого болон Монголбанкнаас баталсан “Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам”-тай нийцүүлэн боловсруулсан дотоод журамтай байна.

ДӨРӨВ. БАНКНААС ЗЭЭЛ ОЛГОХОД ЗЭЭЛДЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА, ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

- 4.1 Банкны Гүйцэтгэх захирал нь Банкны тухай хууль, Монголбанкны шийдвэр, Монголбанкнаас баталсан “Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам”-аар тогтоосон аливаа зээлийн хязгаарлалт болон банкны зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогоор тогтоосон зээл, зээлийн багцын хязгаарлалтаас хэтрүүлэлгүй банкны зээлийн үйл ажиллагааг эрхэлнэ.
- 4.2 Банк нь зээл олгоход тавигдах шаардлагыг зээлийн бодлогын хүрээнд ерөнхий байдлаар болон зээлийн бүтээгдэхүүн бүрийн хувьд тогтоож, холбогдох дотоод журамд нарийвчлан тусгана.
- 4.3 Банк нь барьцаа хөрөнгө шаардагдах зээлийн бүтээгдэхүүн тус бүрт эсхүл ерөнхий байдлаар барьцаалах боломжтой эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж, барьцаалах эд хөрөнгөд тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлно.
- 4.4 Барьцаа хөрөнгө шаардагдах зээлийн бүтээгдэхүүний хувьд барьцаа хөрөнгө авахад баримтлах дараах зарчмыг банк холбогдох дотоод журамдаа тусгасан байна. Үүнд:
 - 4.4.1 Зах зээлд эрэлттэй, борлуулах боломжтой хөрөнгө байх;
 - 4.4.2 Түүх, урлаг соёлын үнэт зүйлс, шашны холбогдолтой эд зүйлс, цэрэг дайны зориулалттай хөрөнгө, хуулиар агнахыг хориглосон ан амьтдын гаралтай түүхий эд, хориотой химийн болон хорт бодис, хүний эд эрхтэн биш байх;
 - 4.4.3 Монголбанкнаас баталсан “Барьцаа хөрөнгийн үнэлгээний журам”-ын дагуу үнэлсэн үнэлгээтэй байх бөгөөд барьцаа хөрөнгийн үнэлгээ нь Монголбанкнаас тогтоосон холбогдох зээл, үнэлгээний харьцаа (LTV) болон банкны дотоод журмаар тогтоосон зээл, үнэлгээний харьцаанд нийцтэй байх;
 - 4.4.4 Барьцаалах эрх үүсэх боломжтой байх;

- 4.4.5 Бусад шаардлагатай гэж үзсэн зарчим.
- 4.5 Банк нь зээл хүсэгчийн хүсэлт, холбогдох баримт материал дээр үндэслэн шаардлагатай тохиолдолд нэмэлт баримт нотолгоо цуглуулж, зээлийн судалгааг дараах байдлаар хийнэ:
- 4.5.1 Зээл хүсэгчийн мэдээлэл буюу анхдагч болон нэмэлт орлогын эх үүсвэрийг баталгаажуулах;
- 4.5.1.a Зээл хүсэгч нь иргэн байх тохиолдолд ажил олгогчийн талаарх мэдээлэл, анхдагч орлогын мэдээлэл буюу цалин, орлого, орлогын давтамж, орлогын төрөл, нэмэлт орлогын эх үүсвэрүүдийг баталгаажуулах;
- 4.5.2.б Зээл хүсэгч нь хуулийн этгээд байх тохиолдолд тухайн хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, бусад санхүүгийн баримт, мэдээллийг хүлээн авч, орлогыг баталгаажуулах.
- 4.5.2 Барьцаа хөрөнгө шаардагдах зээлийн хувьд барьцаа хөрөнгийг шалгаж, баталгаажуулах;
- 4.5.3 Зээл хүсэгчийн мэдээллийг зээлийн мэдээллийн сан, шаардлагатай тохиолдолд улсын бүртгэлийн мэдээллийн сан, татварын мэдээллийн сан, шүүхийн шийдвэрийн сан болон бусад мэдээллийн сангуудаас баталгаажуулах;
- 4.5.4 Зээл хүсэгчтэй хийх ярилцлага, газар дээрх судалгаа, бизнесийн хэтийн төлөв, үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн салбарын одоогийн нөхцөл байдал, ирээдүйн төлөв зэргийг судалж, зээл хүсэгчийн орлого, үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаарх дүгнэлтийг гаргах;
- 4.5.5 Зээл хүсэгчийн орлогын түвшин, орлогын тогтвортой байдал, зардлын хэмжээ, өр-орлогын харьцаа болон бусад санхүү төлбөрийн чадварыг илэрхийлэх харьцааг тооцож, зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг тодорхойлон байгуулах зээлийн гэрээний дагуу төлбөр хариуцагч нь зээл болон хүүгийн төлбөрөө төлж, барагдуулах боломжтой эсэх талаарх дүгнэлт гаргах;
- 4.5.5 Энэ журмын 5.2-г заасан судалгаа, дүгнэлтийг хийх.
- 4.6 Банк зээлийн судалгааг дотоод журам, зааврын дагуу, шаардлагатай бүхий л баримт материалыг үндэслэн үнэн бодитоор хийх бөгөөд зээлийн судалгаа хийх үйл явц, үр дүнг хянадаг шат дараалсан хяналтын тогтолцоотой байна.

ТАВ. ЗЭЭЛ ОЛГОХ ШИЙДВЭР ГАРГАХ ЗАРЧИМ, ҮЙЛ ЯВЦ

- 5.1 Банк нь зээл хүсэгчийн эрсдэлийн түвшинг үнэн, бодитой тогтооход шаардлагатай бүхий л боломжит мэдээллийг цуглуулж, зээлдэгчийг таньж мэдэн дотоод журмын

ТӨСӨЛ

- дагуу зээлийн судалгааг хийж, зээл хүсэгчийн зээлжих зэрэглэлийг тогтоосны дараа зээлийг зөвхөн шаардлага хангасан этгээдэд олгоно.
- 5.2 Банк нь энэ журмын 5.1-ын дагуу зээлийг олгохдоо зөвхөн банкнаас тухайн харьяалагдах зээлийн бүтээгдэхүүний хувьд баталсан хүү, хугацаатайгаар олгоно.
- 5.3 Банк зээл олгох шийдвэр гаргахдаа зээл хүсэгчийн талаарх дараах болон бусад шаардлагатай хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:
- 5.3.1 Зээлийн зориулалт;
- 5.3.2 Зээлийг эргэн төлөх эх үүсвэр, чадамж;
- 5.3.3 Зээл хүсэгчийн эрсдэлийн түвшин болон түүний эдийн засаг, бизнесийн орчны өөрчлөлтийн үеийн мэдрэмтгий байдлын шинжилгээ;
- 5.3.4 Зээл хүсэгчийн зээлийн түүх, зээл хүсэх үеийн зээлийн эргэн төлөлтийн чадамж буюу зээл хүсэхээс өмнөх үеийн болон одоогийн санхүүгийн байдал, ирээдүйн мөнгөн урсгалын төсөөлөлд тулгуурлан хийсэн санхүүгийн тооцоолол;
- 5.3.5 Хуулийн этгээдэд олгох зээлийн хувьд зээл хүсэгчийн бизнесийн туршлага, үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн салбарын ирээдүйн төлөв байдал, зээл хүсэгчийн тухайн зах зээлд эзлэх хувь, байр суурь;
- 5.3.6 Зээл хүсэгчийн ирээдүйн эрсдэлийн түвшинг харгалзан боловсруулсан санал болгох зээлийн гэрээний нөхцөлүүд;
- 5.3.7 Барьцаа, баталгаа, батлан даалт.
- 5.4 Банк зээл олгох шийдвэр гаргахдаа тухайн зээлийн эрсдэл болон түүнд харгалзах банкны хүлээгдэж буй өгөөж, байгуулж болзошгүй эрсдэлийн санг тооцоолж, харгалзан үзнэ.
- 5.5 Банк зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээл хүсэгчийг барьцаа хөрөнгө, батлан даагчтай байхыг шаардаж болох боловч барьцаа хөрөнгө, батлан даалт нь зээл олгох шийдвэр гаргах, зээлийн гэрээний нөхцөлийг тогтооход нөлөөлөх үндсэн хүчил зүйл болохгүй бөгөөд зээл хүсэгчийн зээлийг эргэн төлөх эх үүсвэр, чадамж, мөнгөн урсгал нь зээл олгох шийдвэр гаргах үндсэн хүчин зүйл байна.
- 5.6 Хамтын санхүүжилттэй олгох зээлийн хувьд удирдагч болон оролцогч банкууд зээлийн эрсдэлийн судалгааг тус тусдаа, хараат бусаар хийж зээл олгох эсэх шийдвэрийг гаргана.
- 5.7 Банк зээлийн эргэн төлөлтийн хуваарийг зээл хүсэгчийн мөнгөн урсгалтай уялдуулан гаргана.

ТӨСӨЛ

- 5.8 Банкны зээл олгох шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь зээлийн хороо(д) байх бөгөөд өөрийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээ, зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, эрсдэлийн түвшнээс хамааран зээлийн хороо(д)-той байна.
- 5.9 Зээлийн хороо(д)-ын бүтэц, үйл ажиллагаа нь банкны зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлого болон банкны бизнесийн стратеги, төлөвлөгөөтэй уялдсан байна.
- 5.10 Зээлийн хороо(д)-ын эрх мэдэл, олгох зээлийн хязгаарыг банк дотооддоо тогтоосон байна. Эдгээр эрх мэдэл ба хязгаарыг тогтоохдоо зээлийн бүтээгдэхүүний төрөл, зээлдэгчийн төрөл, төлбөрийн чадвар, зээлжих зэрэглэл, зээлийн эрсдэл, зээлдэгчийн газарзүйн байршил, үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн салбар, зээлийн бодлого болон Монголбанкнаас тогтоосон зээлийн бусад хязгаарлалт зэргийг харгалзана.
- 5.11 Зээлийн хороо(д)-ын бүрэлдэхүүн, гишүүнчлэл, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны зарчим, горим, тайлагнах давтамжийг холбогдох дотоод журам, зааварт нарийвчлан тусгасан байна.
- 5.12 Зээлийн хороо(д) нь зээлийн үйл ажиллагааны талаар туршлага, мэдлэгтэй, эрсдэлийг үнэлж, шийдвэр гаргах мэргэжлийн ур чадвартай дарга, гишүүдтэй байна.
- 5.13 Зээлийн хороо(д)-ын бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг холбогдох дотоод журамд нарийвчлан тусгасан байна.
- 5.14 Зээлийн хороо(д) нь үйл ажиллагааны тайланг сар бүр бэлтгэж, Гүйцэтгэх захирал болон Эрсдэлийн удирдлага хариуцсан удирдах ажилтанд тайлагнана.
- 5.15 Зээлийн хороо нь зээлийн эрсдэл болон үнийн дүн багатай хэрэглээний зээл, хадгаламж барьцаалсан зээл олгох шийдвэрийг аливаа эрх бүхий албан тушаалтанд итгэмжлэн шилжүүлж болно. Энэ тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны эрх мэдлийн хугацаа, гаргах шийдвэрийн тоо, дүнг хязгаарласан байна.
- 5.16 Энэ журмын 5.15-д заасан зээл олгох шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан нь зээлийн үйл ажиллагааны талаар туршлага, мэдлэгтэй, эрсдэлийг үнэлж, шийдвэр гаргах чадвартай байх бөгөөд түүний үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны зарчим, горимыг холбогдох дотоод журам, зааварт нарийвчлан тусгасан байна.
- 5.17 Банкны зээл олгох шийдвэр нь хараат бус бөгөөд ашиг сонирхлын зөрчилгүй байх буюу дараах тохиолдолд аливаа этгээд зээл олгох шийдвэр гаргах үйл явцад оролцохгүй. Үүнд:
- 5.17.1 Зээлдэгчтэй хувийн болон ажил мэргэжлийн холбоотой байсан эсхүл байгаа;
- 5.17.2 Зээлдэгчтэй шууд болон шууд бус байдлаар санхүү, эдийн засаг, улс төрийн ашиг сонирхолтой.

ТӨСӨЛ

- 5.18 Банкны холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгох зээлийн шийдвэр гаргах эрх бүхий этгээд (Зээлийн хороо)-ийн бүрэлдэхүүнд тухайн зээл хүсэгчтэй харилцан хамааралгүй, холбогдох этгээд биш байх Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн саналын эрхтэй бөгөөд хориг тавих эрхтэйгээр орно.
- 5.19 Энэ журмын 5.18 болон Банкны зээлийн бодлогоор энэ журмын 3.3.10, 3.3.11-д зааснаас бусад тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл зээл олгох шийдвэр гаргалтад оролцохгүй.
- 5.20 Банкны холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгох зээл нь Банкны тухай хууль, Монголбанкнаас баталсан “Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам”-ын хүрээнд бусад харилцагчтай ижил, давуу тал үүсгээгүй нөхцөлтэй байна.
- 5.21 Банк програм хангамж ашиглан зээл олгох шийдвэрийг гаргадаг тохиолдолд холбогдох журам, зааварт үйл ажиллагааны горим, шийдвэрлэх зээлийн бүтээгдэхүүний төрөл, хэмжээг заасан байна.
- 5.22 Энэ журмын 5.21-д заасан журам, зааврыг банкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж боловсруулж, Гүйцэтгэх захирал батална.

ЗУРГАА. ЗЭЭЛИЙН ХУВИЙН ХЭРЭГ

- 6.1. Банк зээлийн бүтээгдэхүүн тус бүрийн хувьд болон ерөнхий байдлаар зээлийн хувийн хэргийн бүрдэлд оруулах баримт материалын жагсаалтыг гаргаж, холбогдох дотоод журамд тусгасан байна.
- 6.2. Банк зээлийн хүсэлтийг хүлээж авахад дараах баримт материалыг бүрдүүлж, зээлийн хувийн хэргийн бүрдэлд хавсаргана. Үүнд:
- 6.2.1 Орлогын нотолгоо;
 - 6.2.2. Ирээдүйн орлогын төсөөлөл;
 - 6.2.3. Барьцаа хөрөнгө шаардагдах зээлийн бүтээгдэхүүний хувьд барьцаа хөрөнгийн баримт материал;
 - 6.2.4. Өмнөх зээл, зээлийн эргэн төлөлтийн түүх;
 - 6.2.5 Зээлийн зориулалт;
 - 6.2.6 Бусад хариуцах өр төлбөр, зээлийн талаарх мэдээлэл;
 - 6.2.7 Банкны дотоод журмаар тогтоосон бусад бүрдүүлэх баримт материал.
- 6.3 Зээлийн хувийн хэрэгт энэ журмын 6.2-т заасан баримт бичгээс гадна дараах баримт, материалыг тухай бүр хавсаргана. Үүнд:

- 6.3.1 Энэ журмын 5 дугаар бүлгийн дагуу цуглуулсан мэдээлэл, хийсэн тооцоолол, судалгаа, зээлдэгчид зээл олгохоос өмнө болон дараа хийсэн зээлжих зэрэглэлийг тогтоохтой холбоотой хийсэн судалгаа, тооцооллууд, санхүүгийн тайлангууд болон бусад холбогдох бүх баримт бичиг;
- 6.3.2 Энэ журмын 7 дугаар бүлгийн дагуу хийсэн зээлийн хяналттай холбоотой бүхий л цуглуулсан баримт бичиг, хийсэн тооцоолол, судалгаа;
- 6.3.3 Зээлдэгчид зээл олгох хүртэлх бүхий л үе шатанд гарсан дүгнэлт, санал (зээлийн хорооны гишүүд санал зөрөлдсөн тохиолдол, зээл олгохоос татгалзах саналтай байсан зээлийн хорооны гишүүний санал, үндэслэл байх тохиолдолд заавал хавсаргах), шийдвэрийг холбогдох баримт бичгийн хамт;
- 6.3.4 Хуулийн этгээдэд олгосон зээлийн хяналтын хүрээнд зээлдэгчээс гаргуулан авсан улирал бүрийн санхүүгийн тайлан болон оны эцэст аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;
- 6.3.5 Монголбанкнаас тогтоосон журмын дагуу хийсэн зээлийн ангилал, ангиллын шилжилт, ангиллыг хийхэд ашигласан баримт, судалгаа;
- 6.3.5 Бүтэц өөрчлөгдсөн зээлийн хувьд үндэслэл, шаардлага, холбоотой судалгаа, шийдвэр, гэрээ;
- 6.4 Хамтын санхүүжилттай зээлийн хувийн хэргийн бүрдлийн шаардлагыг банк холбогдох дотоод журамд тусгайлан тодорхойлсон байна.
- 6.5 Банк зээлийн хувийн хэргийн бүрдлийг тогтмол, тухай бүр шинэчилж, бүрэн гүйцэд байлгах бөгөөд дотоод аудит хариуцсан нэгж нь зээлийн хувийн хэргийн бүрдлийн бүрэн гүйцэд байдалд хяналт тавьж ажиллана.

ДОЛОО. ЗЭЭЛИЙН ХЯНАЛТ

- 7.1 Зээлийн эрсдэлийг бууруулах, учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх зорилгоор банк олгосон зээлд тогтмол хяналт тавьж ажиллана.
- 7.2 Зээлийг хянах болон зээлийн эрсдэлийг үнэлэх бүхий л үйл ажиллагаанд оролцох банкны ажилтнуудын үүрэг, хариуцлагыг зээлийн бодлогын хүрээнд холбогдох журамд тодорхой тусгасан байна.
- 7.3 Банк олгосон зээлийн эргэн төлөлт хийгдэж дуусах хүртэл зээлдэгчийн санхүүгийн байдалд тогтмол хяналт тавьж, зээлдэгчийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварыг үнэлж, дүгнэх заавар, арга аргачлалтай байна.
- 7.4 Банк зээлийг хянах хүрээнд зээлийн бүтээгдэхүүн тус бүрийн хувьд зээлдэгчээс болон бусад эх үүсвэрээс цуглуулах мэдээлэл, баримт бичгийн төрөл, жагсаалтыг холбогдох журамд тодорхой заана.

ТӨСӨЛ

- 7.5 Банк зээлийн төрөл, хэмжээ, хугацаа, эдийн засгийн салбар, эрсдэлийн түвшин зэргээс хамаарч, дотоод журмаар тогтоосон давтамжийн дагуу зээл олгосны дараах хяналтыг хийнэ.
- 7.6 Банк нь зээлийн хяналтын хүрээнд дотоод журмаар тогтоосон давтамжийн дагуу зээлийн эрсдэлийн үнэлгээг хийж, зээлдэгчийн зээлжих зэрэглэлийг шинэчлэн тогтоодог байна.
- 7.7 Банк хуулийн этгээдэд олгосон зээлийн хувьд зээлдэгчээс санхүүгийн тайланг улирал бүр гаргуулан авч, санхүү, төлбөрийн чадварын шинжилгээг хийн ирээдүйн төлөвийг үнэлж, хяналтыг хийнэ.
- 7.8 Банк зээлийн хяналтыг хийхдээ макро эдийн засгийн хүчин зүйлүүд, эдийн засгийн тодорхой салбаруудын нөхцөл байдал зээлдэгчийн төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлж байгаа болон нөлөөлж болзошгүйг судална.
- 7.9 Шаардлагатай тохиолдолд, зээлийн хяналтын хүрээнд банк нь зээлийн баталгаа гаргагч, батлан даагчийн төлбөрийн чадварын судалгааг хийнэ.
- 7.10 Зээлийн хяналтыг хийх үйл ажиллагааны нэгж, албан тушаалтан, түүний үүрэг, хариуцлага болон хяналтыг хийх, эрсдэлийг үнэлэх аргачлалыг холбогдох журам, зааварт тусгасан байна.
- 7.11 Банк зээл олгосноос хойш зээлийн гэрээний хугацаанд барьцаа хөрөнгийг тодорхой давтамжийн дагуу Монголбанкнаас баталсан “Барьцаа хөрөнгийн үнэлгээний журам”-ын дагуу үнэлж, үнэ цэнийн өөрчлөлтийг тогтмол хянана.
- 7.12 Энэ журмын 7.11-ийн дагуу хийсэн барьцаа хөрөнгийн үнэлгээг зээлийн хувийн хэрэгт тухай бүр хавсаргана.
- 7.13 Банк нь зээлийн хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг дараагийн шатны эрх бүхий этгээдэд мэдэгдэх, анхаарал хандуулан холбогдох арга хэмжээ авах тогтолцоотой байх бөгөөд холбогдох баримт материалыг тухай бүр зээлийн хувийн хэрэгт хавсаргана.
- 7.14 Банк зээлийн хяналтаар эрсдэлийг эрт илрүүлэх хүрээнд Урьдчилан сэрэмжлэх нөхцөл (Early warning indicator)-үүд болон эдгээр нөхцөлүүд хангагдсан гэж үзэх тохиолдол (trigger)-уудыг банкны зээлийн бодлогын хүрээнд тодорхойлно.
- 7.15 Урьдчилан сэрэмжлэх нөхцөлүүд болон эдгээр нөхцөлүүд хангагдсан гэж үзэх тохиолдлуудыг зээлийн бүтээгдэхүүнийн төрөл, хэмжээ, зээлдэгчийн үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн салбар тус бүрийн хувьд тусгайлан тодорхойлсон байна.
- 7.16 Урьдчилан сэрэмжлэх нөхцөл хангагдсан зээлийг Тусгай хянах зээлийн жагсаалт (watch list)-д оруулж зээлийн хяналтыг илүү нарийвчлан, сар бүр хийнэ.

ТӨСӨЛ

- 7.17 Энэ журмын 7.16-ийн дагуу хийсэн хяналтын тайланг Эрсдэл хариуцсан удирдах ажилтан, зээл олгох үйл ажиллагаа хариуцсан нэгжийн захирал болон Гүйцэтгэх захиралд сар бүр танилцуулна.
- 7.18 Тусгай хянах зээлийн жагсаалтад орсон зээлд авах дараагийн шатны арга хэмжээг банк зээлийн бодлогод тодорхойлно.
- 7.19 Банк зээлийн төлбөрийг хугацааны сүүл хэсэгт их дүнтэйгээр төлүүлэх (balloon payment) эсхүл хугацааны эцэст бүхэлд нь төлүүлэх (bullet payment) зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай зээлийг Тусгай хянах зээлийн жагсаалтад оруулна.
- 7.20 Банк дараах болон бусад шаардлагатай гэж үзсэн урьдчилан сэрэмжлэх нөхцөлүүдийг тодорхойлно. Үүнд:
- 7.20.1 Зээлдэгчийн үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн салбар эсхүл орон нутагт макро-эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэнээр зээлдэгчийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй болсон эсхүл зээлдэгч ажлаас халагдаж болзошгүй болсон;
- 7.20.2 Технологийн дэвшил, хууль эрх зүйн орчны өөрчлөлт нь зээлдэгчийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй болсон эсхүл зээлдэгч ажлаас халагдаж болзошгүй болсон;
- 7.20.3 Зээлдэгчийн санхүүгийн байдалд мэдэгдэхүйц сөрөг өөрчлөлтүүд гарсан, тухайлбал, хөшүүргийн харьцаа, өрийн үйлчилгээний харьцаа (DSTI) өссөн;
- 7.20.4 Зээлдэгчийн үйл ажиллагааны ашиг, орлого мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан;
- 7.20.5 Тайлант хугацааны орлого нь зээл олгохоос өмнөх орлогын төсөөллөөс мэдэгдэхүйц хэмжээгээр бага байгаа, төслийн бизнес төлөвлөгөө, хэрэгжилт удааширсан, хойшилсон;
- 7.20.6 Зээлдэгчийн хөндлөнгийн зээлжих зэрэглэл буурсан эсхүл буурахаар хүлээгдэж байгаа;
- 7.20.7 Зээлдэгчийн бусад эх үүсвэрээс санхүүжилт татах нөхцөл байдал доройтсон эсхүл гуравдагч этгээдээс үзүүлж байсан санхүүгийн дэмжлэг буурсан, зогссон;
- 7.20.8 Зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтийн чадамжид мэдэгдэхүйц нөлөөлж болзошгүйгээр бизнесийн үйл ажиллагаа удааширсан, сөрөг хандлага үүссэн;
- 7.20.9 Барьцаа хөрөнгийн үнэлгээ буурснаар LTV харьцаа өссөн;

- 7.20.10 Зээлдэгчийн бусад холбогдох зээлүүдийн зээлийн эрсдэл өссөн;
- 7.20.11 Зээлдэгчийн хамаарах компанийн нэгдлийн оролцогчид санхүүгийн хүндрэл үүссэн, зээлийн эрсдэл өссөн;
- 7.20.12 Зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж болохуйц аливаа захиргааны шийдвэр гарсан;
- 7.20.13 Зээлийн хяналтын хүрээнд хийсэн зээлжих зэрэглэл буурсан;
- 7.20.14 Зээлдэгч нь хуулийн этгээд байх тохиолдолд аудитын байгууллагаас зээлдэгчийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргахаас татгалзсан (disclaimer) эсвэл сөрөг дүгнэлт гаргасан (adverse opinion).

НАЙМ.ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ

- 8.1 ТУЗ нь банкны зээлийн үйл ажиллагааг зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлого болон тэдгээрийн хүрээнд баталсан журам зааврын дагуу эрхэлж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогын зохистой, үр ашигтай байдалд үнэлэлт дүгнэлт өгч ажиллана.
- 8.2 Банк нь зээлийн эрсдэл, зээлийн эрсдэлийн удирдлагад тогтмол хяналт тавьж, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг тогтолцоотой байна.
- 8.3 Зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлого, энэ журмын 1.4-д заасан журам, заавар, арга аргачлалын хэрэгжилтэд ТУЗ-ын дэргэдэх Эрсдэлийн хороо хяналт тавьж, хагас жил бүр ТУЗ-д тайлагнана.
- 8.4 Банкны ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо нь жил бүр банкны эрсдэлийн дуршил, зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогын зохистой, үр дүнтэй байдлыг үнэлж, дүгнэн ТУЗ-д тайлагнана.
- 8.5 Банкны эрсдэлийн удирдлагын нэгж нь банк зээлийн үйл ажиллагааг Банкны тухай хууль, Монголбанкны шийдвэр, Монголбанкнаас баталсан “Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам”-аар тогтоосон аливаа зээлийн хязгаарлалт болон банкны зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогоор тогтоосон зээл, зээлийн багцын хязгаарлалтуудаас хэтрүүлэлгүй эрхэлж байгаа эсэхэд хяналт тавьж, сар бүр Эрсдэлийн хороонд тайлагнаж, Гүйцэтгэх захиралд мэдээлнэ.
- 8.6 Банкны эрсдэлийн удирдлагын нэгж энэ журмын 8.5-д заасан хяналтын хүрээнд зөрчлийг илрүүлсэн тохиолдолд банкны Гүйцэтгэх захиралд мэдэгдэж, зөрчлийг арилгах хүрээнд шаардлагатай арга хэмжээг тухай бүр авахуулна.

ТӨСӨЛ

- 8.7 Банкны дотоод хяналтын нэгж нь зээл олгосон шийдвэр, шийдвэр гаргах үйл явц нь холбогдох бодлого, журам, зааврын дагуу байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, улирал бүр Гүйцэтгэх захиралд тайлагнана.
- 8.8 Зээл олгох шаардлагыг хангаагүй эсхүл зээлийн эрсдэлийн дуршил, зээлийн бодлогоор тогтоосон хязгаарлалтууд болон Банкны тухай хууль, Монголбанкны шийдвэр, Монголбанкаас баталсан журмаар тогтоосон хязгаарлалтуудыг зөрчсөн, зээлийн бүтээгдэхүүний тогтоосон хүү, хугацааны нөхцөлөөс ялгаатайгаар олгосон зээлүүдэд банкны Эрсдэлийн удирдлагын нэгж тогтмол хяналт тавьж, сар бүр Эрсдэлийн хороонд тайлагнаж, Гүйцэтгэх захиралд мэдээлнэ.
- 8.9 Банкны дотоод хяналтын нэгж нь зээлийн хувийн хэргийн бүрдлийн бүрэн гүйцэд байдал, зээлийн хувийн хэрэг нь тухай бүр журам зааврын дагуу шинэчлэгдэж байгаа эсэхэд хяналт тавьж, улирал бүр Гүйцэтгэх захиралд тайлагнана.
- 8.10 Зээл олгосны дараах хяналт нь журам, зааврын дагуу зохистой хийгдэж байгаа эсэхэд банкны дотоод хяналтын нэгж хяналт тавьж, улирал бүр Гүйцэтгэх захиралд тайлагнана.
- 8.11 Энэ журмын 8.5, 8.8-д заасан сар бүрийн тайланг банкны Эрсдэлийн удирдлага хариуцсан удирдах ажилтан дараа сарын 15-ны өдрийн дотор Монголбанкны Хяналт шалгалтын газар, Банкны бүтцийн өөрчлөлт бодлогын газарт ирүүлнэ.
- 8.12 Банкны хянан зохицуулагч байгууллага, шүүх, цагдаа, прокурорын байгууллагын ажилтан, албан хаагч банкны зээл олгох шийдвэр гаргалтад нөлөөлөхийг оролдох, банкны баталсан зээлийн бүтээгдэхүүний хүү, хугацаа, зээл олгох шаардлагаас хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авах хүсэлт гаргах тохиолдолд банк тухай бүр, нэн даруй Монголбанканд мэдэгдэнэ.

ЕС. ХАРИУЦЛАГА

- 9.1 Энэ журмын хэрэгжилтэд Монголбанкны Хяналт шалгалтын газар, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч, хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛБАНК